



ХӨСӨГ ТРЕЙД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 сар 28 өдөр

№ 01

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минутад Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал тауэр, 902 тоот Хурлын танхимд хуралдуулав.

Хуралд:

- Ж.Энхтунгалаг 1 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Х.Эрдэнэсанаа 1 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Эй Ди Эм Эм Ди ХХК 96,357 ширхэг хувьцааны саналаар, Итгэмжлэгдсэн төлөөлөгч Т.Солонго /өөрийн биеэр/
- Д.Бадам 88,118 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Г.Маргад 53,916 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/ тус тус оролцож нийт 238,393 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 80.6% хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд болох Т.Өлзийбүрэн, Р.Гансүх, Ц.Дамжин нар өөрийн биеэр оролцов.

Хурлын даргаар томилогдсон С.Болор нь хуралд ирээгүй тул компанийн дүрмийн 7.5-д заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар компанийн Гүйцэтгэх захирал М.Эрдэнэсүхийг хурлын даргаар сонгов.

Хурлаар:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

Хурлын дарга М.Эрдэнэсүх: Сайн байцгаана уу? Хурлын даргаар томилогдсон тул хурлын дэгийн дагуу тооллогын комисс ирцээ танилцуулаад хуульд заасан ирцийн шаардлага хангасан бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Б.Гэрэлмаа хурлын ирцийг танилцуулан, Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 80.6% байгаа тул Монголын Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн

69.1-д заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэх зөвшөөрлийг Хурлын даргад өгөв.

Хурал 15 цаг 30 минутад эхлэв.

СОНССОН НЬ :

Хурлын дарга М.Эрдэнэсүх: 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Тооллогын комиссын даргын танилцуулснаар хурал хүчин төгөлдөр болох нөхцөл бүрдсэн тул хурлаа эхэлье. Та бүхэнд тарааж өгсөн хурлын дэгийн дагуу хурал явагдах ба дараах асуудлыг хэлэлцэнэ.

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батална
3. Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулна

Хэлэлцэх асуудлын дагуу Хурлын дарга 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг уншиж танилцуулав.

Хурлын дарга М.Эрдэнэсүх: Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг уншиж танилцуулъя.

Хурлын дарга ТУЗ-ийн дүгнэлтийг уншиж танилцуулав.

Хурлын дарга М.Эрдэнэсүх: 2026.02.13-ны өдрийн 01 тоот ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилахгүй талаар гаргасан шийдвэрийг танилцуулъя.

Хурлын дарга ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг уншиж танилцуулав.

Хурлын дарга М.Эрдэнэсүх: Хурлаар хэлэлцэх зүйлсийг танилцууллаа. Хувьцаа эзэмшигч нараас асуух асуулт байвал суусан дарааллын дагуу асуугаад явъя.

Хувьцаа эзэмшигч Д.Бадам: Сайн байцгаана уу, Хурлын материалтай танилцсан нэмэлтээр асууж тодруулах зүйл байхгүй байна. Бүтээн байгуулалтын ажил амжилттай хэрэгжсэн гэж харж байна.

Хувьцаа эзэмшигч Эй Ди Эм Эм Ди ХХК-ийн төлөөлөгч Т.Солонго: Сайн байна уу, Миний хувьд мөн санал байхгүй ээ.

Хувьцаа эзэмшигч Г.Маргад: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Миний зүгээс мөн тодруулах зүйл байхгүй.

Хувьцаа эзэмшигч Х.Эрдэнэсанаа: Сайн байна уу, Бүтээн байгуулалтын ажлууд дуусч байнгын ашиглалтад орсон юм байна. Дутуу зүйлс юу байгаа вэ?

Хурлын дарга М.Эрдэнэсүх: Энэ жил төмөр замын төсөл болон ус цэвэршүүлэх байгууламжийн төсөл хийгдэж байгаа ба төлөвлөгөөт хугацаандаа явж байна. Ирэх оны эхний улирал гэхэд дуусчих болов уу гэж харж байна.

Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг: Надад асуулт байхгүй ээ.

Хурлын дарга М.Эрдэнэсүх: За хувьцаа эзэмшигч нараас дахин тодруулах зүйл байхгүй байгаа тул санал хураалтаа явуулаад хурлаа дуусгая. Саналаа хувьцаа эзэмшигч тус бүр саналын хуудсаар өгнө. Тооллогын комиссын дарга саналын хуудас хэрхэн бөглөх зааврыг хувьцаа эзэмшигч нарт танилцуулаад санал авч дууссаны дараа дүнгээ танилцуулна уу.

Хурал 30 минут завсарлаад тооллогын комисс саналаа хурааж, дүнгээ гарган уншиж танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б.Гэрэлмаа: Хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын хуудасны дагуу дараах дүн гарч байна.

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрсөн саналын тоо 238,393 ширхэг буюу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар зөвшөөрсөн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслийг хурлын дарга уншиж танилцуулан, хурлын материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэхийг дурдав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компани 2025 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг танилцуулсныг дурдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

Хурал 17 цаг 00 минутад өндөрлөв.



ХУРЛЫН ДАРГА:

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

М.ЭРДЭНЭСҮХ

Б.АНХБАЯР

